



“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЫЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 01

Хэрлэн сум

2019-оны жилийн үр дүнгийн цалин, урамшуулалт олгох хувь
хэмжээг тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.17 дэх заалт, Эрчим хүчиний салбарын хамтын хэлэлцээрийн гуравдугаар бүлгийн 3.3, Хамтын гэрээний гуравдугаар бүлгийн 3.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. 2019 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлтийг харгалзан компанийн ажилтнуудад олгох жилийн үр дүнгийн урамшууллын хэмжээг батлагдсан цалингийн төлөвлөгөөнд багтаан олгохыг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д зөвшөөрсүгэй.
2. Компанийн ажилтнуудад олгох жилийн үр дүнгийн урамшууллын хувь хэмжээг ажлын сахилга хариуцлага, ажлын бүтээмж, ур чадвар, жилийн ажлын гүйцэтгэлийг харгалзан олгохыг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Ш.Дуламсүрэн/, Цалин, урамшууллын хороо /Г.Пүрэвдорж/-д нарт үүрэг болгосугай.





“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 02

Хэрээн сум

Компанийн 2020 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
төлөвлөгөөний тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалтууд, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.13.5, 7.13.6 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 281 тоот тушаал, Эрчим хүчний сайдын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 15 тоот тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2020 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг хавсралт ёсоор дэмжсүгэй.

2. Компанийн 2020 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн, Төрийн худалдан авах ажиллагааны цахим сайтад тендерийн урилга, үр дүнгийн хамт оруулж олон нийтэд ил тод мэдээллэн, байршуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д даалгасугай.

2.3. Компанийн 2020 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнахыг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Ш.Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.





**“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2020 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 03

Хэрлэн сум

**Г Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны ажлын
төлөвлөгөөний тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Дорнод бусийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 9.7 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бусийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.
2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд, хурлаар хэлэлцэх асуудлыг бэлтгэн, биелэлтийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Нарантуяа/-д үүрэг болгосугай.





**“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2020 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 04

Хардлын сум

**Компанийн 2020 оны бизнес төлөвлөгөөг
батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2020 оны 01 сарын 08-ны өдрийн 15 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2020 оны бизнес төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.
2. Компанийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, бизнес төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Ш.Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.





“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЫЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 05

Хэрээн сум

Г 50 МВт-ын төслийн санхүүжилтийн тухай ¹

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Компанийн дурмийн 7 дугаар зүйлийн 7.3.17 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 29 дүгээр тэмдэглэл, Эрчим хүчний дэд сайдын 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн б/385 тоотыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Чойбалсангийн дулааны цахилгаан станцыг 50 МВт-ын хүчин чадлаар шинээр өргөтгөхөд шаардлагатай байгаа 79,488,266 /далан есөн сая дөрвөн зуун наян найман мянга хоёр зуун жаран зургаан/ ам.долларын санхүүжилтийн эх үүсвэрийн 75.5 хувь буюу 60,000,000 /жаран сая/ ам.долларыг Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан хийгдэх зээлийн гэрээ байгуулах саналыг дэмжсүгэй.
2. Төслийн зээлийн барьцаа хөрөнгийн асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д даалгасугай.





134

“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЫЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 08

Хэрлэн сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал
даргалагчийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.3 дахь хэсэг, Эрчим хүчний сайдын 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн а/857 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн хурлыг удирдах хурал даргалагчаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн /С.Ариунболд/-г томилсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулан хэлэлцэх асуудлуудыг удирдамжийн дагуу шийдвэрлүүлэхийг хурал даргалагч /С.Ариунболд/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД





“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТОЛОӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 07

Хэрээн сум

Г Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг 7
сонгож батлах тухай

Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалт, Эрчим хүчний салбарын Төрийн өмчит хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01 дүгээр тогтоол, Эрчим хүчний сайдын 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн a/857 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэлийг сонгож баталсугай.

төлөөлөн удирдах
зөвлөлийн гишүүд



М.БАТГЭРЭЛ

В.ДАРХАНБААТАР
Н.АМАРТӨВШИН

Б.БАЯСГАЛАНБААТАР

С.АРИУНБОЛД

Д.ДУЛМАА

Р.ПҮРЭВДОРЖ

Ш.ДУЛАМСҮРЭН

Д.ГАН-ОЧИР

580019003



“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

138

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 08

Хэрлэн сум

**Г Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 7
зарлан хуралдуулах тухай**

Монгол Улсын “Компанийн тухай” хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10, 60 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.3 дахь хэсэг, Эрчим хүчний сайдын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн а/705 тоот удирдамжийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 14.30 цагт Эрчим хүчний яамны хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудасны загварыг 2 дугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг 3 дугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг 4 дүгээр хавсралтаар тус тус хавсралтаар баталсугай.
3. Хурлын тооллогын комиссыг доорх бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.
Тооллогын комиссын дарга: Ж.Гантулга /ЗУХ-ийн дарга/
Гишүүд: Д.Гэрэлчuluun /СБХ-ийн дарга/
А.Мэндсайхан /XXX-ийн мэргэжилтэн/
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргыг Хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдөөс сонгосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах өдрийг 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөр, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалт гаргах бүртгэлийг 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөр, саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөр тус тус тогтоосугай.

ДАРГА



М.БАТГЭРЭЛ

580019010



165

**“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗОВЛОЛИЙН
ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 01 одер

Дугаар 09

Хэрээн сум

**Г Компанийн 2019 оны аудитлагдсан жилийн
эцсийн санхүүгийн тайлангийн дүнгийн тухай**

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 96 дугаар зүйлийн 96.5 дахь заалт, “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7.3.12 дахь заалт, Үндэсний аудитын газрын 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 06/816 тоот дүгнэлт, Эрчим хүчний сайдын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн а/705 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус компани 2019 онд 49,742,723,723.60 /дөчин есөн тэрбум долоон зуун дөчин хоёр сая долоон зуун хорин гурван мянган долоон зуун хорин гурван төгрөг жаран мөнгө/ төгрөгийн нийт орлоготой, 50,130,090,733.64 /тавин тэрбум нэг зуун гучин сая өрэн мянга долоон зуун гучин гурван төгрөг жаран дөрвөн мөнгө/ төгрөгийн зардалтай, 422,356,475.61 /дөрвөн зуун хорин хоёр сая гурван зуун тавин зургаан мянга дөрвөн зуун далан таван төгрөг жаран нэгэн мөнгө/ төгрөгийн алдагдалтай ажилласан тул компанийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүнг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, баталгаажуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /М.Батгэрэл/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Ш.Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.



580019011



“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 10

Хэрлэн сум

Г Компанийн 2019 оны зорилтот түвшингийн
биелэлт, Гүйцэтгэх захиралтай байгуулсан
контрактын гэрээний үүргийн биелэлтийн тухай

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлийн 76.1.9, 83 дугаар зүйлийн 83.6 дахь заалт, “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7.3.10 дахь заалт, Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан “Эрчим хүчний салбарын төрийн өмчит компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактыг дүгнэх, урамшуулал олгох түр журам” -ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь заалт, 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, 3.4, 3.5 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн а/705 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компани 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Гүйцэтгэх захирал байгуулсан 2019 оны “Контрактын гэрээ”-ний үүргийн биелэлтийг 85.3 оноотойгоор “Сайн” гэж дүгнэсүгэй.

2. Компанийн 2019 оны зорилтот түвшин болон Гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын гэрээний үүргийн биелэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, баталгаажулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /М.Батгэрэл/-д даалгасугай.





“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛОЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 11

Хэрэгсүүлэлт

Г Компанийн 2019 оны үйл ажиллагааны
тайлан дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дахь хэсэг, 84 дүгээр зүйлийн 84.4.1, 96 дугаар зүйлийн 96.5 дахь заалт, “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7.17 дахь заалт, Үндэсний аудитын газрын 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 06/816 тоот дүгнэлт, Эрчим хүчний сайдын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн а/705 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. Компанийн 2020 оны зорилтот түвшинг үзүүлэлт тус бүрээр биелүүлж, өртөг зардлыг бууруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, санхүү төлбөрийн чадварыг сайжруулах талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д үүрэг болгосугай.

3. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /М.Батгэрэл/-д даалгасугай.

ДАРГА



М.БАТГЭРЭЛ

590019016



262

“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 12

Хэрээн сүм

**Г Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны
зардлын төсвийн тухай**

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 15 тоот тушаал, Эрчим хүчний сайдын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн а/705 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг 104,673,000 /Нэг зуун дөрвөн сая зургаан зуун далан гурван мянга/ төгрөг буюу хавсралт ёсоор дэмжсүгэй.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Нарантуяа/-д үүрэг болгосугай.





265

**“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 13

Хэрэгсүүлэлт

Г Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 46.8 дэх заалт, “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 4.1, 7.3.13 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн a/705 тоот тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн 2019 оны аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцлийн дүнгээр тайлант үед 422,356,475.61 /дөрвөн зуун хорин хоёр сая гурван зуун тавин зургаан мянга дөрвөн зуун далан таван төгрөг жаран нэгэн мөнгө/ төгрөгийн алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д даалгасугай.
3. Энэхүү тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо /Ш.Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.





“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 14

Хэрэгжүүлсүүдийн
Хэрэгжүүлсүүдийн

Г Нэр дэвшүүлэх түр хороо байгуулах тухай

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх заалт, Эрчим хүчний сайдын 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн а/940 албан тоотыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бусийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх түр хороог дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Дарга: В.Дарханбаатар
Гишүүд: Б.Баясгаланбаатар
С.Ариунболд

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг холбогдох хууль, журамд нийцүүлэн сонгон шалгаруулахыг Нэр дэвшүүлэх түр хороо /В.Дарханбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАТГЭРЭЛ





“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

275

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 15

Хэрэн сүм

“Зээл авах, их хэмжээний хэлцэл хийх тухай”

“Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь заалт, 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх хэсэг, 87.2 дахь заалт, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 29 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 458 тоот тогтоол, “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7.3.16 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөхөд шаардлагатай 60,000,000.0 /жаран сая/ ам долларын зээлийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын Хөгжлийн банктай байгуулахыг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д зөвшөөрсүгэй.
2. “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн зээлийн барьцаанд тавих 60,000,000.0 /жаран сая/ ам долларын өртөг бүхий үндсэн болон туслах тоноглол, эрчим хүчний барилга байгууламж, бусад тоноглолыг хавсралтаар баталж, барьцаалж хэлцэл хийх эрхийг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д олгосугай.
3. Монгол Улсын Хөгжлийн банктай байгуулсан зээлийн гэрээ, хэлцэл хэрхэн шийдвэрлэсэн талаарх тайланг Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнахыг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА



М.БАТГЭРЭЛ

ГИШҮҮД
Н.АМАРТӨВШИН

Д.ДУЛМАА

В.ДАРХАНБААТАР

Ш.ДУЛАМСҮРЭН

С.АРИУНБОЛД

Б.БАЯСГАЛАНБААТАР

Г.ПҮРЭВДОРЖ

Д.ГАН-ОЧИР



“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 04-дээр

Дугаар 16

Хэрлэн сум

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2, 31.3 дахь хэсэг, 31.3.1, 31.3.3 дахь заалтууд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолын 2.1, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2, 1.4, 2, Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бусийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өргтөө бүрэн нехсөн, цаашид ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон, хавсралтанд заасан 146 нэр төрлийн 3,014,019,620 /турван тэрбум арван дөрвөн сая арван есөн мянга зургаан зуун хорин мянга/ төгрөгийн балансын үнэтэй үндсэн хөрөнгийг бүртгэлээс хасах саналыг дэмжсүгэй.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2 дугаар хэсэгт заасан материалыг бүрдүүлж, үндсэн хөрөнгө данснаас хасах асуудлыг Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөл /Ө.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА



М.БАТГЭРЭЛ



10

“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 29 одор

Дугаар 17

Хэрлэн сум

Гүйцэтгэх захиралтай контракт байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.9 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 22, 25 дугаар зүйл, Эрчим хүчний төрийн өмчит хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах контрактыг хавсралтаар баталсугай.
2. “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Гэндэнжамц овогтой Отгонбаатартай контрактыг нэг жилийн хугацаатай байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (М.Батгэрэл)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА М.БАТГЭРЭЛ





“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 18

Хэрээн сум

Г 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөнд тодотгол оруулах тухай

Монгол Улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл 76.1.18 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн а/2732 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бусийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн тодотголыг нэгдүгээр, хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний тодотголыг хоёрдугаар хавсралтаар тус тус дэмжсүгэй.
2. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөний тодотголыг Эрчим хүчний яаманд хүргүүлж шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-т даалгасугай.

ДАРГА



М.БАТГЭРЭЛ



180

“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 19

Хэрлэн сум

Г Сахилгын шийтгэл ногдуулах тухай 7

Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулийн 131 дүгээр зүйл 131.1.2, Гүйцэтгэх захиралтай байгуулсан “Контракт”-ын 6.2 дахь заалт, Эрчим хүчиний сайдын 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн а/2602 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрчим хүчиний сайдын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн а/4564 тоот албан даалгаврыг зөрчиж “Саруул өргөө констракшн” ХХК-ийн гүйцэтгэх байгаа засварын ажилд “Дорнод бусийн эрчим хүчиний систем” ТӨХК-ийн ажилтнуудыг ажиллах боломж олгож хариуцлага алдсан тул гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарын албан тушаалын цалинг гурван сарын хугацаагаар 20 (хорин) хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.
2. Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарын цалин хөлснөөс заасан хувиар бууруулж тооцохыг компанийн Ерөнхий нягтлан бодогч /Д.Гэрэлчулуун/-д үүрэг болгосугай.

ДАРГА



М.БАТГЭРЭЛ

580019050



“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 23

Хэрэн сүм

Г Зээл авах, их хэмжээний хэлцэл
хийх тухай Г

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь заалт, 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх хэсэг, 87.2 дахь заалт, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 29 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 458 тоот тогтоол, “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7.3.16 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөхөд шаардлагатай 420,000,000.0 /дөрвөн зуун хорин сая/ юаны зээлийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын Хөгжлийн банктай байгуулахыг гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д зөвшөөрсүгэй.
2. “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн зээлийн барьцаанд тавих үндсэн болон туслах тоноглол, эрчим хүчний барилга байгууламж, бусад тоноглолыг нэгдүгээр хавсралтаар, төслийн хүрээнд шинээр бий болох хөрөнгийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, компанийн зээлийн барьцаанд борлуулалтын орлогыг барьцаалахыг зөвшөөрч, холбогдох барьцааны гэрээг байгуулах эрхийг гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д олгосугай.
3. Монгол Улсын Хөгжлийн банктай байгуулсан зээлийн гэрээ, хэлцэл хэрхэн шийдвэрлэсэн талаарх тайланг Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнахыг гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 05 дугаар тогтоол, мөн 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 15 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА

ГИШҮҮД

Д.БАТЗОРИГ



В.ДАРХАНБААТАР

Н.АМАРТӨВШИН

Б.БАЯСГАЛАНБААТАР

С.АРИУНБОЛД

Б.ШҮР-ЭРДЭНЭ

Г.ПҮРЭВДОРЖ

Ш.ДУЛАМСҮРЭН

Д.ГАН-ОЧИР



“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 21

Хэрлэн сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал
даргалагчийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.3 дахь хэсэг, Эрчим хүчний сайдын 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн а/3472 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хурлыг удирдах хурал даргалагчаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн /В.Дарханбаатар/-г томилсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулан хэлэлцэх асуудлуудыг удирдамжийн дагуу шийдвэрлүүлэхийг хурал даргалагч /В.Дарханбаатар/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



Д.БАТЗОРИГ

В.ДАРХАНБААТАР

Н.АМАРТӨВШИН

Б.БАЯСГАЛАНБААТАР

С.АРИУНБОЛД

Б.ШҮР-ЭРДЭНЭ

Г.ПҮРЭВДОРЖ

Ш.ДУЛАМСҮРЭН

Д.ГАН-ОЧИР



“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЫЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 22

Хэрээн сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг
сонгож батлах тухай

Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 17 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн а/3472 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Батзоригийг сонгож баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



Д.БАТЗОРИГ

В.ДАРХАНБААТАР

Н.АМАРТӨВШИН

Б.БАЯСГАЛАНБААТАР

С.АРИУНБОЛД

Б.ШҮР-ЭРДЭНЭ

Г.ПҮРЭВДОРЖ

Ш.ДУЛАМСҮРЭН

Д.ГАН-ОЧИР



“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 24

Хэрээн сум

Г Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх
хороодын ажиллах журам батлах тухай

Монгол Улсын “Компанийн тухай” хуулийн 80.4, Компанийн дүрмийн 7.3.13 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 142 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бусийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны ажиллах журамыг нэгдүгээр хавсралтаар нэр дэвшүүлэх хорооны ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар Цалин, урашууллын хорооны ажиллах журамыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

ДАРГА
Д.БАТЗОРИГ



107

“ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 10 одор

Дугаар 25

Хэрээн сум

Г Компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн
төлөвлөгөөний төслийн тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлийн 76.1.1, Компанийн дүрмийн 7.3.1, 7.3.17 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн саналыг нэгдүгээр хавсралтаар, хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төслийг хоёрдугаар хавсралтаар тус тус дэмжсүгэй.
2. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг Эрчим хүчний яаманд хүргүүлж шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д үүрэг болгосугай.



Б.БАТЗОРИГ

580020002